

**Петро Матад ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл Ажиллагааны Шинэчилсэн Мэдээлэл**

Петро Матад Компани нь Давсан Толгой-7 цооногийг ("ДТ-7" гэх) 1,733 метрийн гүнд хүртэл өрөмдөж, Цагаанцавын формацийн доод талын хувирмал чулуулагт хүргэснийг мэдэгдэж байна.

ДТ-7 цооногийн өрөмдлөгөөр хоёрдугаар зэргийн хагар алтай гурван блокоос бүрдэх хагарлын болон атираат хураагуур бүхий Хэтийн Төлөв Сайтай "Мод" Талбайн Цагаанцавын дээд хэсэг болон Доод Цагаанцавын агуулагч давхаргыг судалсан.

Өрөмдлөгийн явцад Цагаанцавын дээд хэсэг 1,149 метрийн гүнд буюу бидний урьдчилан таамаглаж байснаас 22 метрийн дээр тогтоогдсон. Петрофизикийн анхны шинжилгээгээр дунджаар 25 хувийн нүх сүвшилтэй, нийтдээ 4.8 метрийн зузаан, тос илрүүлэх боломжтой гурван хэсэг үе тогтоогдлоо. Мөн дээрхи хөдөлгөөнт нүүрсустөрөгч байх боломжтой гурван хэсэг үеүүдийн хооронд 19 хувийн дундаж нүх сүвшилтэй, 18.5 метр зузаан ус агуулагч давхарга тархаж тогтсон байна. Давсан Толгойн хойд хэсэгт байрлах XIX талбайн Тосон Уулын ордод иймэрхүү байдлаар салаавчлан тогтсон тост үе болон ус агуулсан элсэн чулуун агуулагч давхаргууд нийтлэг байдаг. Цагаанцавын хамгийн дээд хэсэгт тогтоогдсон нүүрсустөрөгчийн гурван үеийг цаашид үргэлжлүүлэн туршилт хийх, мөн ДТ-7 цооногийн түвшингээс дээш 75 метр-т нэмэлт цооног өрөмдөх талаар судалгаа хийгдэж байгаа бөгөөд энэ түвшинд нүүрсустөрөгчийн ханалт илүү өндөр байж болзошгүй хэмээн үзэж байгаа юм.

Доод Цагаанцавын формаци 1,208-аас 1,703 метр хүртэл үргэлжилсэн ба 1,542 метрт бага хэмжээний нүүрсустөрөгчийн ханалт илэрсэн. Агуулагч давхаргын чанартай, 23 метрийн зузаан элсэн чулуун дотор 17 хувийн дундаж нүх сүвшил бүхий арван хоёр нимгэн үеүүд тархаж тогтсон байна.

ДТ-7 цооногийн өрөмдлөг, бэхэлгээний яндан суулгалт, цементлэх ажлуудыг хийж дуусгасан. Одоо Матад XX талбайн Давсан Толгой дахь хэтийн төлөв бүхий арван хоёр тусдаа талбайг судлах өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд шинээр ДТ-8 цооногийг өрөмдөхөөр өрмийн цамхагийг нүүлгээд байна.

ДТ-8 цооногийн өрөмдлөгийг өнөөдөр эхлүүлэхээр төлөвлөсөн. ДТ-8 цооног нь энэ оны 06 дугаар сард өрөмдсөн ДТ -5 цооноогоос зүүн хойш 700 метр-т, ДТ-5 цооногийн түвшингээс доош 38 метр-т, Дачин компанийн XIX талбай дахь 19-62 дугаар цооноогоос урагш 1,8 км-т, мөн цооногийн түвшингээс дээш 80 метр-т байрлана. Энэхүү цооногийн өрөмдлөгөөр ДТ-5 цооноогоос илэрсэн нүүрсустөрөгчийн ханалт багатай, элсэн чулууны нимгэн үе болон 19-62 дугаар цооноогоос илэрсэн тостой элсэн чулуун зузаан үеийн хооронд үргэлжлэх эртний голын хөндийн агуулагч давхаргын үргэлжлэлийг судлах юм. ДТ-5 цооног болон XIX талбайн 19-62 дугаар цооногуудын мэдээллийг харьцуулсан судалгаа, шинжилгээний үр дүнд Доод Зүүнбаянгийн элсэн чулуун үе дотор хоёрд агч давхаргазүйн хураагуур тогтоогдсон ба энэхүү хураагуурыг судлах зорилгоор ДТ-8 цооногийн байрлалыг тодорхойллоо. Доод Зүүнбаянгийн элсэн чулуу нь XIX талбайн Хойд Тосон Уулын үндсэн агуулагч давхаргыг бүрдүүлдэг бөгөөд ДТ-8 цооногийн өрөмдлөг амжилттай үр дүн үзүүлсэн тохиолдолд энэ нь Давсан Толгойд шинээр нүүрсустөрөгч хуримтлуулах систем байгааг батлах юм.

ДТ-1-ээс ДТ-8 хүртэлхи бүх цооногуудын байрлалыг харуулсан зургийг Компанийн www.petromatad.com цахим хуудсанд байрлуулсан энэхүү Үйл ажиллагааны мэдээллийн цахим хувилбараас харж болно.

Түүнчлэн Давсан Толгойд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй цооногийн туршилтын хөтөлбөрийн явцын талаархи шинэчилсэн мэдээлэл хүргэж байна. Петро Матад ХХК-ийн Матад ХХ талбайгаас урагш 150 км-ын зайд Хятад улсын хилийн боомт дээр цооногийн туршилтын үйлчилгээний өрөм болон тоног төхөөрөмжийг ачсан 135 ачааны машин хүлээгдэж байна. Монгол Улсын үндэсний баяр наадамүргэ лжилж байгаатай холбогдуулан тус хилийн боомт хаалттай байсан бөгөөд өнөөдөр нээгдэх юм. Хилээр нэвтрэхээр хүлээж буй автомашины урт дарааллын улмаас замын хөдөлгөөн ихсэх хэдий ч Петро Матад болон туслан гүйцэтгэгч Ди Кью И Интернешнл нар тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг удахгүй хэвийн үргэлжлүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Бид цооногийн туршилтын ажилд шаардагдах бусад бүх бэлтгэлийг хангасан. Цооногийн үхэлгээн д (шүүр гаргах) ашиглах тэсрэх бодис, зөвшөөрөл, туршилтын багаж хэрэгслийг бэлтгэсэн ба туршилтыг явуулах олон улсын мэргэжилтнүүд ажлаа эхлэхэд бэлэн байна.

Компанийн геологийн мэргэжилтнүүд Давсан Толгойн 3 хэмжээст судалгааны дахин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд загварыг сайжруулж, тодорхой болгох зорилгоор энэхүү ажилд сүүлийн үеийн боловсруулах багц мэдээллийг ашиглаж байна. Түүнчлэн цооногийн боловсруулагдсан мэдээллийг үнэлгээнд нэмж ашиглаж байна. Энэхүү өргөн цар хүрээтэй ажлыг 08 дугаар сарын сүүлээр дуусгахаар төлөвлөж байна.

Бид Давсан Толгойн ойролцоо хийгдсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны боловсруулалтыг саяхан дуусгаж, өмнө нь гүйцэтгэсэн 2,700 км судалгааны үр дүнтэй нэгтгэж, дахин боловсруулалт хийхэд бэлэн болоод байна. Энэхүү ажлыг гүйцэтгэснээр бид Давсан Толгойн баруун болон зүүн талын талбайнуудын талаар илүү тодорхой мэдлэгтэй болж, шинээр өрөмдлөгийн ажил хийх байрлалыг тодорхойлох боломжтой болно.

Түүнчлэн бид Матад ХХ талбайн урд хэсгийн гурван дэд сав газарт 2 хэмжээст сейсмийн судалгааг хийн боловсруулалтыг хийж дуусгалаа. Боловсруулалтын анхны үр дүнгээр дээрхи дэд сав газруудын үн ий хэмжээ нь Давсан Толгойн ойр орчмын сав газруудын дүнтэй ижил байгааг харууллаа. Шинээр 1,300 тууш км шугамаар хийгдсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны тайлалын ажил үргэлжилж байна.

Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даг МакГэй хэлэхдээ:

“Бид Давсан Толгойн өрөмдлөгийн хөтөлбөр ийнхөө явцад нүүрсустөрөгч илрүүлж, агуулагч давхаргын үтгий н талаархи урьдчилсан дүгнэлтээ баталгаажуулж чадсандаа баяртай байна.

Давсан Толгой дахь талбайгаа дэс дараатайгаар судалж, одоогийн байдлаар нийт 7 цоон өрөмдөж, 6 цооногоос нүүрсустөрөгч илрүүлээд байна. Компанийн удирдлага болон хайгуулын багийнхан ДТ-5, ДТ-7 цооногуудын үр дүн төдийлэн хангалтгүй, мөн ДТ-6 цооног хуурай цооног байсны үлэн зөвшөөрч, нарийн төвөгтэй геологийн бүтэц бүхий Давсан Толгойн өрөмдлөгийн хөтөлбөрийн явцад иймэрхүү үр дүнгүүд гарна гэдгийг урьдчилан тааварлаж байсан гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Бид өрөмдсөн цооног бүрээс геологийн загвараа сайжруулж, цооногийн байрлалаа сонгоход шаардлагатай чухал

мэдээллийг олж авсан. Ингэснээр бид хэтийн өлөв сайтай талбай даа үргэлжлүүлэн өрөмдөж, Матад ХХ талбайнүлдсэн хэсгийг амжилттай судлах боломжтой болж байгаа юм.

Матад ХХ талбайд хийгдэх цооногийн туршилт зэрэг хайгуулын бусад ажлуудын бэлтгэл урагштай байна. Саяхан дахин боловсруулж дуусгасан 3 хэмжээст сейсмийн судалгааны зургийг гаргах нь бидний бас нэгэн чухал зорилт байсан. Давсан Толгойгоос бусад талбайнуудыг нарийн дэс дараалалтайгаар судалж байгаа бөгөөд ойр орчмын хэтийн өлөв тэй болон хэтийн өлөв сайтай талбайнуудыг улам нарийвчлан судалж, бусад дэд сав газрууд дахь хайгуулын ажлаа өргөжүүлэх зорилготой ажиллаж байна.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай үбээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм.үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралдүсн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспект Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100